



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/221

Улаанбаатар хот

Хууль дагаж гарах стандарт, дүрэм,
журам, бусад шийдвэрийн тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан эдгээр хуулийг дагаж шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт, дүрэм, журам, бусад эрх зүйн баримт бичиг, шийдвэрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад заасан стандарт, дүрэм, журам, бусад эрх зүйн баримт бичиг, шийдвэр болон эдгээртэй холбоотой дагалдах эрх зүйн баримт бичгүүдийг 2016 оны 8 дугаар сарын 01-ний дотор шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулахыг хариуцсан газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Шаардлагатай гэж үзвэл холбогдох яам, агентлагийн болон мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоог хийж, 2016 оны төсвийн тодотгол, 2017 оны төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Стратегийн бодлого төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/, Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, яамны харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, хуулийг дагаж шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт, дүрэм, журам, бусад эрх зүйн баримт бичиг, шийдвэрийг боловсруулахад шаардлагатай гэж үзвэл Олон улсын байгууллагаас санхүүжилтийн дэмжлэг авахад санаачлага гарган ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтүяа/-д үүрэг болгосугай.


САЙД



С.ЛАМБАА

080807

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 06 сарын 24 өдрийн
А/001 дугаар тушаалын хавсралт



Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуультай холбогдуулан
шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт, дүрэм, журам, бусад шийдвэрийн жагсаалт

№	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Хариуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
1.	5.4.Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ (СЭЗХ), ХШҮДАГ
2.	6.2.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	-
3.	7.3.Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэх журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ
4.	7.6.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ
5.	8.3.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тусламж, үйлчилгээний жагсаалт, журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	-
6.	9.4.Эх барихын тусламж, үйлчилгээнд мөрдөх заавар, үр хөндөх, жирэмслэлтийг таслах ажилбар гүйцэтгэх журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	-
7.	10.3.Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйлчлүүлэгчийг эрэмбэлэх болон яаралтай			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	-

№	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Хариуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
	тусламжийг зохион байгуулахтай холбогдох заавар, журам, маягт					
8.	11.3.Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах, үйлчлэх хүрээг тогтоох журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ
9.	12.5.Сувилахуйн болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвийг байгуулах журам, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ
10.	13.5.Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ
11.	14.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүний нөөцөд тавих шаардлага		✓		ЭТХ (ЭМБХЗГ)	НЭМХ, ЭЭХХ (ЭМБХЗГ)
12.	15.22.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журам		✓		СЭЗХ (СБТГ)	ЭМБХЗГ
13.	15.29.Нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах журам			✓	СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ)
14.	21.2.Улсын төсөв, даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур		✓		СБТГ (СЭЗХ)	ЭТХ (ЭМБХЗГ), ХШУДАГ
15.	21.4.Нэмэлт үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбогдох журам		✓		СБТГ (СЭЗХ)	-

№	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Хариуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
16.	21.6.Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	✓			СБТГ (СЭЗХ)	ЭТХ (ЭМБХЗГ), ХШУДАГ
17.	22.3.Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ

Эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэлбэгдуулан
шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт, дүрэм, журам, бусад шийдвэрийн жагсаалт

№	Эрүүл мэндийн тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Хариуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
1.	19.28.Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам			✓	СБТГ	ТЗУГ
2.	19.29.Хэрэгцээний үнэлгээ хийх, мэргэжлийн үйл ажиллагааны төслийг үнэлэх болон хэрэгцээний тодорхойлолт гаргах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам, орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам			✓	ТЗУГ	СБТГ, ЭТХ (ЭМБХЗГ)
3.	19.29.Хэрэгцээний тодорхойлолт болон тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг		✓		ТЗУГ	СЭЗХ (СБТГ), ЭТХ (ЭМБХЗГ)
4.	25.15.Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар, холбогдох маягт			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ

№	Эрүүл мэндийн тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Харлуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
5.	25.16.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын болон мэргэшлийн зэргийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, мэргэшлийн зэргийн болон төгсөлтийн дараахь сургалтыг төгсөгчид олгох үнэмлэх, гэрчилгээний загвар			✓	ЭТХ (ЭМБХЗГ)	СБТГ
6.	25.16.Төгсөлтийн дараахь сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, зардлын жишиг, сургалтын тэтгэлэг олгох шалгуур, тэтгэлгийн хэмжээ, мэргэшлийн зэргийн шалгалтын төлбөр, зардлын жишиг		✓		ЭТХ (ЭМБХЗГ)	СЭЗХ (СБТГ)
7.	25.19.Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам			✓	СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ)
8.	29.9.Хуулийн 29.2, 29.5-д заасан эрүүл мэндийн ажилтанд тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох, аймагт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд 3 болон 5 жил тутамд мөнгөн тэтгэмж олгох журам		✓		СЭЗХ (СБТГ)	ЭТХ (ЭМБХЗГ)
9.	45.3.Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт			✓	СБТГ	ЭТХ, НЭМХ (ЭМБХЗГ)

№	Эрүүл мэндийн тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Хариуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
10.	16.3 Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм			✓	ЭТХ, НЭМХ (ЭМБХЗГ)	СБТГ
11.	16.5 Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амыг хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйл-лэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах			✓	СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ)
12.	17.2 Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах			✓	СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ)
13.	19.4 Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл			✓	СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ), ТЗУГ
14.	22.4 Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуур			✓	СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ)
15.	22.4 Магадлан итгэмжлэлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг		✓		СБТГ (СЭЗХ)	ЭМБХЗГ
16.	24.2 Улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх болон хяналт тавих журам		✓		СБТГ (СЭЗХ)	ЭТХ (ЭМБХЗГ), ХШҮДАГ

№	Эрүүл мэндийн тухай хуулийн заалт	Засгийн газраар батлуулах	Бусад байгууллагатай хамтарч батлах	Дангаар батлах	Хариуцах газар, хэлтэс	Хамтрах газар, хэлтэс
17.	37.4.Оношилгоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа болон био технологи, нано технологи, инновацийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд судалгаа, шинжилгээ явуулах, турших, баталгаажуулах, бүртгэх, мэдээлэх, тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам		✓		СБТГ	ЭТХ (ЭМБХЗГ)